



"АИЖЭЙЭИЭИЧ-АУДИТ" ХХК

**ХӨХ ГАН  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

2014 оны 12-р сарын 31-нээрх үндэгдэл  
Аудитын тайлан

Улаанбаатар хот  
2015.03 сар

**КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

Компанийн нэр /Оноосон нэр/	Монгол Англи	"Хөх ган" ХК
Компаний удирдлага	И.Батболд	Гүйцэтгэх захирал
Компанийн хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороолол, 50-р байр 15 давхарт Утас:(976)-70071777 Факс:(976)-70071777	
Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:	9010001075	
Регистрийн дугаар:	5126142	
Бүртгэгдсэн он сар	2007.12.07	
Үйл ажиллагааны чиглэл	Ангижруулсан төмрийн үйлдвэрлэл	
Санхүү		Санхүүгийн менежер
	Н.Цэцэгдэмбэрэл	Ерөнхий нягтлан бодогч
Ажилчдын тоо	230 орчим ажилчидтай	
Аудитын компани	"Ай Жэй Эй Эйч -Аудит" ХХК Нягтлан бодох бүртгэл, тагвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага	
Аудитын компанийн хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Жора төв 310,311 тоот Утас: 976-11450279, Факс: 976-11-450279.	

**2014 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 5-6 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь “Хөх ган” Хувьцаат Компанийн /Компани гэх/ 2014 оны 12-р сарын 31-ны өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгах үүднээс хийгдсэн болно.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2014 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайланг жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйцэтгэл, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайланг бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- ✓ Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдөж
- ✓ Ул үндэстэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- ✓ СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- ✓ Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг үйл ажиллагааны суурийг үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- ✓ Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловруулж, хэрэглэж, ажиллуулах
- ✓ Компанийн санхүүгийн байдлыг аливаа хугацаанд үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх
- ✓ Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- ✓ Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ✓ Заль мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрийг урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн

Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөх буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

“Хөх ган” ХК-ийн 2014 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

Ц.Батболд



Гүйцэтгэх захирал

ТТА6782-00-5126142

Н.Цэцэгдэмбэрэл

Нягтлан бодогч



НИЙТЛЭН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТАЙЛАН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН

“Хөх ган” ХК

“АН ЖАН ЭН С”

2015 оны 05 сар 11 өдөр

№ 246/А

### “Хөх ган” ХК-ийн хувьцаа эзэмшигч танаа

#### Хараат бус аудиторын дүгнэлт

“Хөх ган” ХК-ний 2014 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдлийн үнэмлэх тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлого бусад тайлбар тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

#### Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Үзлийг ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хариуцах тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үндэслэн энэхүү хариуцлагад хамаарна.

#### Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний хариуцлага бол хийсэн аудитаа үндэслэн эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах явдал билээ. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу явуулсан. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлан материаллаг алдаагүй гэсэн үг үндэслэлтэй нотолгоог олж авах байдлаар аудитыг төлөвлөж, гүйцэтгэх ба 80 үийн шаардлагуудыг мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн ба тодруулгын талаархи үндэслэлтэй нотолгоог олж авахын тулд гүйцэтгэх горимуудыг багтаадаг. Сонгох горим нь аудиторын үнэлэлт дүгнэлт үүн дотроо зальт ажиллагаа ба алдааны улмаас санхүүгийн тайлан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдлийн үнэлгээнээс хамаардаг. Энэ үр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь компанийн дотоод хяналтын үр дүртэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг төлөвлөхийн тулд компанийн санхүүгийн тайланг бэлтгэх, үндэслэн


толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг авч үздэг. Аудит нь удирдлагын мөнгөн нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэлтэй байдал, ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдлын үнэлгээ түүнчлэн санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын үнэлгээг багтаадаг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах үндэслэлийн бүрдүүлэхэд хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

**Дүгнэлт:**

Бидний аудитлагдсан санхүүгийн тайлан нь “Хөх ган” ХК-ийн 2014 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон таллант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв байдтай илэрхийлсэн байна.

ЗАХИРАЛ



Г.ЭНХМАА

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2014 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

(мянган төгрөгөөр)

	2013	2014
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгөн хөрөнгө	63,229,9	5,000,0
Дансны авлага	1,834,493,3	3,284,293,6
Татвар, НДШ-ийн авлага	161,714,9	107,287,9
Бусад авлага	25,500,0	2,000,0
Бараа материал	2,401,995,2	1,172,833,0
Урьдчилж төлсөн зардал / тооцоо /	55,403,9	63,721,2
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>4,542,337,2</b>	<b>4,632,986,4</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө, цэвэр	11,020,969,8	11,701,225,8
Биет бус хөрөнгө	3,712,531,9	3,712,531,9
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>14,733,501,7</b>	<b>15,413,757,7</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>19,275,838,9</b>	<b>20,046,744,1</b>
<b>Өр төлбөр</b>		
Дансны өглөг	8,537,174,7	10,876,633,0
Цалингийн өглөг	47,662,2	101,5,8
НДШ-ийн өглөг	48,809,5	1,087,4
Татварын өглөг	21,439,9	2,629,4
Бусад өглөг	5,654,9	1,234,7
Урт хугацаат зээл	3,000,000,0	2,250,000
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>11,660,741,2</b>	<b>13,267,630,3</b>
Өмч / хувийн /	10,131,755,8	10,131,755,8
Нэмж төлөгдсөн капитал	56,213,1	1,000,0
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	(2,572,871,2)	(3,496,035,1)
Тайлангийн үеийн	(323,581,6)	(823,833,9)
Өмнөх үеийн	(2,249,289,7)	(2,572,871,2)
<b>Өмчийн дүн</b>	<b>7,615,097,7</b>	<b>6,739,313,8</b>
<b>Нийт өр төлбөр, өмчийн дүн</b>	<b>19,275,838,9</b>	<b>20,046,744,1</b>

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2014 оны 12дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

	(мянган төгрөгөөр)	
	2013	2014
Борлуулалтын орлого	162,640,1	1,771,023,4
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	166,259,7	1,830,638,2
Нийт ашиг (алдагдал)-ын дүн	(3,619,6)	(59,614,8)
Бусад орлого	-	18,0
Үйл ажиллагааны зардал	333,573,5	739,106,5
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(337,193,1)	(798,153,3)
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	(13,613,9)	(27,783,9)
Орлогын татварын өмнөх ашиг (алдагдал)	(323,579,2)	(825,783,9)
Орлогын албан татвар зардал	2,3	
Цэвэр ашиг (алдагдал)	(323,581,5)	(825,783,9)

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салмагүй хэсэг болно



**ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛИЙН ТАЙЛАН**

2014 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(мянган төгрөгөөр)

	Хувьцаат капитал	Нэмж Төлөгдсөн капитал	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2012 оны 12 сарын 31	10,131,755,8	56,213,1	-	10,187,968,9
Гаргасан хувьцаат капитал			(2,249,289,7)	(2,249,289,2)
2013 оны 12 сарын 31	10,131,755,8	56,213,1	(2,572,871,2)	7,615,097,7
Гаргасан хувьцаат капитал				
2014 оны 12 сарын 31	10,131,755,8	56,213,1	(3,398,655,1)	6,789,313,8

*Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.*

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2014 оны 12дугаар сарын 31-нээр дуусгавар болсон жилийн хувьд

(мянган төгөсөөр)

	2013	2014
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого</b>	<b>28,872,7</b>	<b>619,189,3</b>
Борлуулалтын болон худалдан авагчдаас орсон мөнгө	5,000,0	
Даатгалын нөхөн олговороос хүлээн авсан мөнгө	7,902,9	19,764,0
Бусад мөнгөн орлого	15,969,8	603,425,3
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>(3,232,252,2)</b>	<b>(2,317,276,2)</b>
Ажиллагчдад олгосон мөнгө	(342,741,3)	(637,788,7)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	(126,358,1)	(182,717,3)
Түүхий, эд материал худалдан авахад төлсөн мөнгө	(2,211,847,0)	(527,217,2)
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	(67,096,8)	(76,928,9)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	(180,378,4)	(249,562,0)
Төлсөн хүү	(38,958,3)	(412,087,3)
Төлсөн орлогын татвар	(126,186,1)	(86,893,0)
Бусад	(138,686,2)	(156,112,8)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(3,203,379,5)</b>	<b>(1,698,086,9)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
Бусадад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	(5,716,2)	
Бусад	2,699,6	
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(1,500,0)	129,9
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(25,800,0)	
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(30,316,7)</b>	<b>(129,9)</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,263,300,0	2,000,000,0
Бусад	32,975,6	13,7
Зээлийн төлөлт	(3,935,0)	(413,000,1)
Бусад	(1,358,7)	
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,290,981,9</b>	<b>1,642,587,6</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>57,285,8</b>	<b>(57,509,2)</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,944,1	63,729,9
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,229,9	7,000,7

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн саллигүй хэсэг болно.

## ТОДРУУЛГА 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Хөх ган” ХК нь анх Ангижруулсан төмрийн үйлдвэрийг барьж байгуулахаар Монгол Сингапурын хамтарсан хөрөнгө оруулалттай ХХК-иар үүсгэн байгуулагдсан бөгөөд хөрөнгө оруулагч нар хоёр талаас 7,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын хийсэн боловч нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай болсны улмаас Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 06 дугаар сарын 12 ны өдрийн 137 тоот тогтоолоор ХК /Хувьцаат компани/ болон өөрчлөгдөж хөрөнгийн зах зээлд хувьцаа гарган бордуулж 3.0 тэрбум гаруй төгрөгийн хөрөнгийн эх үүсвэрийг татан төвлөрүүлжээ.

2007 онд жилдээ 40000 тн төмрийн хүдрийн баяжмал боловсруулж 30000 тн. 92-98% -ийн төмрийн агууламж бүхий ангижруулсан төмөр үйлдвэрлэх хүчин чадлтай үйлдвэрийн эхний шугамыг Эрдэнэт хотын Говил багийн нутаг дэвсгэрт барьж төгссөн нь одоо нийт 230 гаруй ажиллагсадтай болтлоо хөгжиж ирсэн байна.

Үйлдвэр нь Монгол улсад анхны Ангижруулсан төмрийг гарган авсан бөгөөд 2010 оны 03 дугаар сард Монгол Улсын Засгийн Газар.МХАҮТ-аас хамтран зохион байгуулсан “Монголд үйлдвэрлэв-2009” үзэсгэлэнд орлоцож ангижруулсан төмөрөөр Гранпри шагнал авсан байна.

## ТОДРУУЛГА 2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ЗАРЧИМ

### 2.1 Нягтлан бодох бүртгэлийн үндэс

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт цаашид (СТОУС гэх), Олон улсын санхүүгийн тайлагналын стандартын Тайлбарын байнгын хорооноос баталсан тайлбар болон Монгол улсын зохих хууль тогтоомжийг үндэслэн бэлтгэсэн.

### 2.2 Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг бэлтгэсэн валют

Компанийн үйл ажиллагааны валют нь Монгол улсын үндэсний валют төгрөг юм.

### 2.3 Үнэлгээ

Санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэдэг.

#### **2.4 Нягтлан бодох бүртгэлийн суурь**

Компани нягтлан бодох бүртгэлийн аккурель суурьд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

#### **2.5 Санхүүгийн тайлан бэлтгэх төсөөлөл**

Компани одоо болон алс ирээдүйд үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэдэг.

#### **2.6 Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкны зах харилцах дансуудаас бүрдэнэ. Мөнгө түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үндэр бүртгэдэг. Гадаад валютаархи мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

#### **2.7 Гадаад валютын гүйлгээ**

Гадаад валютаархи мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан албан ханшаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг.

Түүхэн өртгөөр тодорхойлогдсон гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийг түүний өртгийг тодорхойлох үед байсан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Зах зээлийн үнээр илэрхийлэгдсэн гадаад валютаархи мөнгөн бус зүйлсийн түүний өртгийг тодорхойлох үед байсан албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийн үлдэгдэлд балансын өдрөөр Монгол банкнаас зарласан албан ханшаар ханшийн тэгшитгэлийн олз гаргаар хүлээн зөвшөөрдөг. Энэ нь ханшийн зөрүүгийн бодит бус олз ба гарз байна.

#### **2.8 Бусад авлага**

Байгууллага, иргэдэд буцаан төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон мөнгө, татвар, шимтгэлийн авлагыг бусад авлагаар бүртгэдэг. Эдгээр авлагын тухайн үеийн нэхэмжлэх дүнгээр тайлагнадаг. Авлагын хувьд насжилт, цуглох ажиллагаа, магадлалыг үнэлэн найдваргүй авлагын нөөцийн сан байгуулдаггүй.

#### **2.9 Урьдчилж төлсөн зардал, тооцоо**

Худалдан авах бараа, үйлчилгээний үнийн урьдчилгаа, дараагийн тайлант үед хамаарах зардлыг урьдчилж гарсан зардал, тооцоо дансанд бүртгэдэг. Урьдчилж гарсан зардал, тооцоог тайлант үеийн холбогдох хөрөнгө, зардал дансад хамруулна.

### 2.10 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд анхны өртгөөс хуримтлагдсан элдэв, хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр тайлагнадаг.

Анхны өртөг нь хөрөнгийг худалдан авсан үнэ дээр түүнийг олж бэлтгэхэд гарсан зардал, капиталжуулсан засварын зардлыг нэмсэн дүнгээс бүрддэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүнийг ашиглалтанд орсон хугацаанаас эхлэж, хөрөнгийн ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар тооцож байгуулнаг.

Элэгдэл тооцох арга болон хугацаа нь Монгол улсын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн заалтад нийцэх бөгөөд үндсэн хөрөнгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн төрөл	ашиглагдах хугацаа (жишээ)
Барилга, байгууламж	40
Уул уурхайн тоног төхөөрөмж	10
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга, эд хогшил	10
Компютер, дагалдах хэрэгсэл	3
Бусад хөрөнгө	10

Үндсэн хөрөнгөнд хийсэн урсгал болон их засварын зардлыг засвар хийх тухай бүр тооцож бүртгэнэ.

Засварын зардал нь үндсэн хөрөнгийн анхдагч үнэлгээний үед тогтоосон бүтээмжийг дээшлүүлэхүйц, компанийн хүртэх ирээдүйн эдийн засгийн өгөөжийн нэмэгдүүлэхүйц, ашиглагдах хугацааг уртасгахаар байвал тэдгээрийг капиталжуулах ёстой. Бусад засварын зардлыг урсгал засвар гэх бөгөөд тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа үлдэгдэл өртгийн дүнгээр хөрөнгө данснаас хассаны гарзыг, худалдан борлуулах үед хөрөнгийн үлдэгдэл өртөг, худалдсан үнийн зөрүүгээр хөрөнгө худалдан борлуулсны олз, гарзыг хүлээн зөвшөөрдөг.

### 2.11 Биет бус хөрөнгө

Ажил үйлчилгээний нийлүүлэлтэд болон удирдлагын зориулалтаар ашигласнаар эзэмшиж байгаа биет шинж чанаргүй, харьцангуй удаан хугацаагаар ашиглагдах хөрөнгийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг хөрөнгийн ашиглагдах жилийг үндэслэн шулуун шугамын аргаар тооцдог.

Биет бус хөрөнгийн хорогдуулгыг тооцох арга болон хугацаа нь Монгол Улсын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн заалтад нийцэх бөгөөд биет бус хөрөнгийн хорогдуулга тооцох хугацаа дараах байдалтай байна.

Ангилал	Ашиглагдах хугацаа (жилоор)
Программ хангамж	3
Ашиглагдах хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10
Ашиглагдах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө	хүчин төгөлдөр байх хугацаа

### 2.12 Дансны өглөг

Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбогдон зээлээр худалдан авсан бараа, материалын үнэ, хүлээн авсан үйлчилгээний үнэ болон үйл ажиллагааны зарцыг хуримтлуулснаас үүссэн өглөгийг дансны өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Дансны өглөгийг худалдан авсан бараа, үйлчилгээний нэрлэсэн үнээр бүртгэдэг.

### 2.13 Бусад өглөг

Компанийн ажиллагчидтай цалин, тэтгэвэр болон бусад тооцоогоор үүссэн өглөг болон бусад аж ахуй нэгж, иргэдтэй үүссэн дансны өглөгөөс бусад өр төлбөрийг бусад өглөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### 2.14 Татварын өглөг

Монгол улсын хуулийн дагуу улс, орон нутгийн төсөв, нийгмийн даатгаланд санд төлж байгаа аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, хураамжийн өр төлбөрийг татварын өглөг гэж ангилсан.

### 2.15 Урт хугацаат өр төлбөр

Урт хугацаат өр төлбөрт нэг жилээс дээш хугацаанд төлөх бусад байгууллага, хувь хүнд өгөх өглөгийг бүртгэдэг.

Компани үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, үндсэн хөрөнгө худалдсан эвх, уурхай баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт болон ашигт малтмалын хайгуул, ашиглалтын лицензтэй холбоотой зардал, үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд зориулж хувь нийлүүлэгчээс авсан санхүүжилтыг урт хугацаат өр төлбөрт бүртгэнэ.

#### **2.16 Эзэмшигчдийн өмч**

Эзэмшигчдийн өмч нь хувьцаа эзэмшигчээс оруулсан хөрөнгө, хуримтлагдсан ашгаас бүрдэнэ. Эзэмшигчдийн өмчийг түүхэн өртгөөр нь санхүүгийн тайланд илэрхийлдэг.

Хувьцаат капитал нь эзэмшигчдээс оруулсан энгийн хувьцааны дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд нийт дүн нь нэгж хувьцааны нэрлэсэн үнийг нийт хувьцааны тоогоор үржүүлсэн дүн байна.

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь өмнөх болон тайлант жилүүдийн үйл ажиллагааны цэвэр дүнг илэрхийлдэг бөгөөд нэрлэсэн дүнгээр санхүүгийн тайланд тусгадаг.

#### **2.17 Орлого**

Орлого нь хүлээн авсан, эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй бодит үнэ нэлгээр хэмжигдэнэ.

#### **2.18 Үйл ажиллагааны зардал**

Компанийн удирдлагын болон үндсэн үйл ажиллагаанд хамаарах зардал нь үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрөх ба үйл ажиллагааны зардлыг тайлант хугацаанд ногдох дүнгээр нь бүртгэдэг.

#### **2.19 Болзошгүй өр төлбөр**

Болзошгүй өр төлбөр нь компанийн өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсэх боломжтой үүрэг хариуцлага бөгөөд түүний орших байдал нь компанийн бүрэн хяналтанд ороогүй, зөвхөн ирээдүйд нэг буюу хэд хэдэн үйл явдлын тохиолдол эс тохиолдлоор батлагдах одоогийн үүрэг хариуцлага юм.

Болзошгүй өр төлбөрийг барагдуулахын тулд эдийн засгийн өгөөжийг агуулсан нөөцийг гадагш шилжүүлэх шаардлагатай гэдэг нь магадлалтай биш, ут үүрэг хариуцлагыг төлөх төлбөрийн дүнг найдвартай хэмжих боломжгүй тул балансад хүлээн зөвшөөрдөггүй.

## 2.20 Компанийн орлогын албан татвар

Компани санхүүгийн жилийн татвар ногдуулах орлого, түүд ногдуулсан орлогын албан татварыг Монгол улсын “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн дагуу тодорхойлж тайлагнадаг.

Тухайн хуулийн дагуу 3.0 тэрбум төгрөг хүртэлх татвар ногдуулах жилийн орлогод, 10 хувиар, 3.0 тэрбум төгрөгөөс дээш татвар ногдуулах жилийн орлого өлсөн бол 300.0 сая төгрөг дээр 3.0 тэрбумаас дээш давсан орлогын дүнгийн 25 хувиар нэмж, орлогын албан татвар ногдуулж төлдөг.

## 2.21 Хувь хүний орлогын албан татвар

Монгол улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуулиар компанийн ажиллагсад болон гэрээт ажилчдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогоод 10 хувиар хувь хүний орлогын албан татварыг суутгаж төсөвт төлөх үүрэг хүлээдэг. Мөн оршин суугч бус татвар төлөгчид шилжүүлсэн орлогоос Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 20 –н хувиар дундын суутгал хийдэг. Давхар татвар ноогдуулахаас зайлсхийх тухай Олон улсын хэлэлцээр бүхий улс орны оршин суугч бус татвар төлөгчдийн хувьд энэхүү татварын түвшинг (0) хүртэл бууруулдаг.

## 2.22 Нийгмийн даатгалын шимтгэл

Монгол улсын “Нийгмийн даатгалын тухай ” хуулийн дагуу компанийн ажиллагсдад олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын дүнгээс даатгуулагчид 10 хувиар, ажил олгогчоос 11-13 хувиар тооцож нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэг хүлээдэг.

## 2.23 Нэмэгдсэн өртгийн албан татвар

Монгол улсын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” хуулиар нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) ногдох бараа, ажил үйлчилгээний орлогод 10 хувиар тооцож НӨАТ төлдөг.

Мөн хуулиар НӨАТ ногдох бараа, ажил үйлчилгээний орлогын хэмжээ хуулийн этгээдийн орлогын албан татварын тайлангаар 10.0 сая ба түүнээс дээш төгрөгт хүрсэн өдрийн дараа сараас НӨАТ төлөгчөөр бүртгүүлдэг.

Үндсэн үйлдвэрлэл, ажил үйлчилгээний борлуулалтын орлого 10.0 сая төгрөгт хүрсэн эсэхээс үл хамааран Монгол улсад 2.0 сая ам.доллар ба түүнээс дээш



хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн хуулийн этгээд сайн дураараа НӨАТ төлөгч болно.

### ТОДРУУЛГА 3. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗҮЙЛС

Тайлант хугацааны эцсээрх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

	2013	2014
Төв касс (төгрөг)	64,2	170,8
Үйлдвэрийн касс (төгрөг)	22,200,3	6,057,6
<b>Бэлэн мөнгөний үлдэгдэл</b>	<b>22,264,5</b>	<b>6,228,4</b>
<i>Банкин дахь төгрөгийн харилцах данс</i>		
ХХБанк	1,284,2	403,3
Төрийн банк	123,6	123,6
Хаан банк-1	24,034,8	632,2
Хаан банк-2	15,292,8	3,0
<i>Банкин дахь валютын харилцах данс (1)</i>		
ХХБанк-доллар	57,4	53,0
ХХБанк-юань	29,4	24,4
Хаан банк-доллар	0,9	
Төрийн банк-доллар	61,7	61,6
Хаан банк-юань	80,7	71,2
<b>Банкин дахь харилцах дансны үлдэгдэл</b>	<b>40,965,5</b>	<b>1,372,3</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн</b>	<b>63,230,0</b>	<b>7,600,7</b>

Мөнгө нь Төв болон үйлдвэрийн касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалттай банкин дахь валютын болон төгрөгийн харилцах дансдуудаас бүрдсэн байна.

### ТОДРУУЛГА 4. АВЛАГА

	2013	2014
Дотоодын байгууллагаас авах авлага	1,136,871,7	104,746,3
Гадаадын байгууллагаас авах авлага	56,227,3	56,227,3
ААХ-с авах авлага	44,737,8	33,065,2
Захирал удирдлагаас авах авлага	25,500,0	2,040,0
Компани хоорондын авлага	596,656,5	3,080,000,0
Бусад авлага	161,714,9	3,080,000,0
<b>Авлагын дүн</b>	<b>2,021,708,2</b>	<b>3,389,581,4</b>

Дээрх авлагууд нь хөтөлсөн бүртгэлтэй таарч байгаа ба үлдэгдэл нь 3,389,581,4 мянган төгрөгийн авлага нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна.

**ТОДРУУЛГА 5. БАРАА МАТЕРИАЛ**

	2013	2014
Бэлэн бүтээгдэхүүн	855,822,2	839,845,3
Дуусаагүй үйлдвэрлэл	11,035,4	
Үйлдвэрийн туршилтын зардал	810,171,1	
Барилгын материал	52,582,5	31,301,9
Сэлбэг материал	103,210,9	101,601,0
Шатах тослох материал	14,179,0	755,5
Аж ахуйн материал	51,516,2	12,200,1
Хүнсний материал	2,521,4	574,0
Түүхий эд материал	500,956,5	185,805,2
<b>Авлагын дүн</b>	<b>2,401,995,2</b>	<b>1,172,083,0</b>

**ТОДРУУЛГА 6. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ ТООЦОО /**

	2013	2014
Урьдчилж төлсөн зардал		
НӨТ-ийн урьдчилгаа		
Цалингийн урьдчилгаа		
Бэлтгэн нийлүүлэгчдийн урьдчилгаа	55,403,9	63,721,2
ААХ-д дараа тайлангаар урьдчилгаа		
<b>Урьдчилж төлсөн зардлын дүн</b>	<b>55,403,9</b>	<b>63,721,2</b>

**ТОДРУУЛГА 7. ҮНДСЭН ХӨРӨНГӨ**

А. Үндсэн хөрөнгийн тайлант оны хөдөлгөөнийг харуулбал дараах байдалтай байна.

	2013	2014
Барилга	3,809,384,4	3,909,531,6
Байгууламж	160,147,1	
Машин тоног төхөөрөмж	8,040,138,9	9,047,295,8
Жижиг тоног төхөөрөмж	66,960,5	
Тээврийн хэрэгсэл	724,318,0	724,318,0
Тавилга эд хогшил	37,451,6	53,479,6
Эд хогшил	15,898,1	
Бусад үндсэн хөрөнгө	395,347,9	628,744,0
<b>Үндсэн хөрөнгийн дүн</b>	<b>13,249,646,5</b>	<b>14,500,309,0</b>

Б. Хуримтлагдсан элэгдэл

	2013	2014
Барилга	326,028,5	437,606,4
Байгууламж	14,346,5	
Машин тоног төхөөрөмж	1,768,441,2	2,578,223,5
Жижиг тоног төхөөрөмж	11,499,9	
Тээврийн хэрэгсэл	74,880,3	771,106,6
Тавилга эд хогшил	25,378,8	41,267,4
Эд хогшил	7,992,2	
Бусад үндсэн хөрөнгө	109,4	739,0
<b>Үндсэн хөрөнгийн дүн</b>	<b>2,228,676,8</b>	<b>3,088,942,9</b>

ТОДРУУЛГА 8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	2013	2014
Биет бус хөрөнгө	3,712,531,9	3,712,531,9
<b>Биет бус хөрөнгийн дүн</b>	<b>3,712,531,9</b>	<b>3,712,531,9</b>

ТОДРУУЛГА 9. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

	2013	2014
Дансны өглөг	8,537,174,7	10,876,633,0
Цалингийн өглөг	47,662,2	84,045,8
ХХОАТ-ын өглөг	21,439,9	17,629,5
НДШ-ын өглөг	48,809,5	38,087,3
Бусад татварын өглөг		-
ААХ-д өгөх өглөг	5,654,9	4,231,7
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>8,660,741,2</b>	<b>11,017,630,4</b>

Богино хугацаат өглөгүүд бүртгэлээрх өглөгтэй тохирч байна. Хугацаандаа төлөгдөөгүй ХАОАТатварын өр 17,629,5 мянган төгрөг, НДШ-ийн 38,087,3 мянган төгрөг байгаа нь татварын байгууллагад хоног тутамд төлөх хүү буюу цалингийн хэмжээг нэмэгдүүлж байдгийг байнга бодолцож байх.

**ТОДРУУЛГА 10.УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**

	2013	2014
Урт хугацаат зээл	3,000,000,0	2,250,000,0
Урт хугацаат өр төлбөрийн нийт дүн	<u>3,000,000,0</u>	<u>2,250,000,0</u>

**ТОДРУУЛГА 11.ХУВЬЦААТ КАПИТАЛ**

	2013	2014
Энгийн хувьцаа	10,131,755,8	10,131,755,8
Хувьцаат капиталын нийт дүн	<u>10,131,755,8</u>	<u>10,131,755,8</u>

**ТОДРУУЛГА 12.ХУРИМТЛАГДСАН АШИГ /АЛДАГДАЛ/**

	2013	2014
Өмнөх үеийн	(2,084,420,5)	(2,084,420,5)
Тайлангийн үеийн	(488,450,7)	(821,483,9)
Хувьцаат капиталын нийт дүн	<u>(2,572,871,2)</u>	<u>(3,393,655,1)</u>

**ТОДРУУЛГА 13.НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ**

	2013	2014
Нэмж төлөгдсөн капитал	56,213,1	56,213,1
Хувьцаат капиталын нийт дүн	<u>56,213,1</u>	<u>56,213,1</u>

**ТОДРУУЛГА 14.БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО**

	2013	2014
Борлуулалтын орлого /ББ/	151,125,5	1,771,623,3
Борлуулалтын орлого /ТЭМ/	10,969,0	-

Борлуулалтын орлого /СББ/	545,6	
Борлуулалтын орлогын дүн	<u>162,640,1</u>	<u>1,771,623,3</u>

**ТОДРУУЛГА 15.БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ**

	2013	2014
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	157,931,3	1,830,688,2
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг /ТЭМ/	8,328,4	
Борлуулсан бүтээгдэхүүний өртгийн дүн	<u>166,259,7</u>	<u>1,830,688,2</u>

**ТОДРУУЛГА 16. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ**

	2013	2014
Цалин хөлс	124,279,7	140,505,0
Нийгмийн даатгалын шимтгэл	35,346,4	23,121,6
Бичиг хэргийн зардал	696,3	1,186,3
Ашиглалтын зардал	1,077,8	
Тээврийн зардал	13,531,1	2,724,0
Албан томилолтын зардал	12,745,7	9,921,4
Түүхий эд материалын зардал		
Элэгдлийн зардал	20,184,7	284,727,4
Зар суртчилгааны зардал	113,2	-460,0
Шуудан, холбооны зардал	4,788,9	4,947,3
Шатахууны зардал	198,9	1,405,0
Зээлийн хүүгийн зардал	80,678,7	160,972,2
Бусад зардал	39,932,0	86766,9
Үйл ажиллагааны зардлын дүн	<u>333,573,5</u>	<u>706,737,1</u>

**ТОДРУУЛГА 17. ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО, ЗАРДАЛ**

	2013	2014
Валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус орлого	31,414,7	18,016,8
Бусад	(17,800,8)	
Үндсэн бус үйл ажиллагааны орлогын дүн	<u>13,613,9</u>	<u>18,016,8</u>

**ТОДРУУЛГА 18.ХОЛБООТОЙ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ТОМООХОН ГҮЙЛГЭЭ**

	2013	2014
Бэрэн групп	10,517,564,0	10,802,678,6
<b>Нийт дүн</b>	<b>10,517,564,0</b>	<b>10,802,678,6</b>

Бэрэн групп-д оны эхэнд 10,517,564,0 мянган төгрөгийн өртэй байсан ба тайлант хугацаанд 285,114,5 мянган төгрөгийн зээл авч 2014 оны жилийн эцэст 10,802,678,6 мянган төгрөгийн өртэй гарсан байна.

**ТОДРУУЛГА 19. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ЗАРДАЛ**

Санхүүгийн тайлангаар 1,771,623,4 мянган төгрөгийн орлого олж 2,597,425,3 мянган төгрөгийг зарцуулж 825,783,9 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан тул аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхгүй.

Аудитын тайлан бичсэн:

Аудитор



Н.Уранчимэг

Аудиторын туслах

Ц.Гэрэлмаа